

ЖУРМЫН ТӨСӨЛ
ОЛОН НИЙТЭД ХЭЛЭЛЦҮҮЛЭХ

ХУВЬЦААТ КОМПАНИ ХЭЛБЭРТЭЙ БАНКНЫ ХУВЬ
НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, БҮТЦЭД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЗӨВШӨӨРЛИЙН ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Хувьцаат компани хэлбэртэй банк шинээр хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас гаргах, аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох, банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нэмж хувьцаа авах, банк хувьцаа болон хувьцаанд хамаарах үнэт цаасаа эргүүлэн худалдан авахад Монголбанкнаас урьдчилан зөвшөөрөл авах, банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулахад Монголбанкинд мэдэгдэхтэй холбоотой харилцааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд дараах байдлаар өөрчлөлт орох тухай бүр Монголбанкнаас урьдчилан зөвшөөрөл авна. Үүнд:

1.2.1. Банк хувьцаа болон хувьцаанд хамаарах үнэт цаас гаргах;

1.2.2. Аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох;

1.2.3. Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч банкны нийт гаргасан хувьцааны 1 (нэг) болон түүнээс дээш хувиар хувьцаа нэмж эзэмших;

1.2.4. Банк хувьцаа болон хувьцаанд хамаарах үнэт цаасаа эргүүлэн худалдан авах.

1.3. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд энэ журмын 1.2-т зааснаас бусад байдлаар өөрчлөлт орох тухай бүр Монголбанкинд мэдэгдэнэ.

1.4. Монголбанкнаас энэ журамд заасны дагуу зөвшөөрөл олгосон тохиолдолд банк хувьцаа болон хувьцаанд хамаарах үнэт цаасыг нийтэд санал болгон, эсхүл хаалттай хүрээнд гаргахаар бүртгүүлэх, хувьцаа болон хувьцаанд хамаарах үнэт цаасыг худалдах, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах үйл ажиллагааг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагын холбогдох журмаар зохицуулна.

1.5. Банкны тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2, 69 дүгээр зүйлийн 69.1.14-т заасан арга хэмжээг хэрэгжүүлж буй банканд энэ журам хамаарахгүй.

ХОЁР. БАНКНЫ ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, БҮТЦЭД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХАД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

2.1. Банк хувьцаа болон хувьцаанд хамаарах үнэт цаасыг нийтэд санал болгон гаргахаар энэ журмын 1.2.1-д заасны дагуу Монголбанкнаас зөвшөөрөл авахдаа зөвшөөрөл хүссэн албан бичгийг дараах баримт бичгийн хамт Монголбанкинд ирүүлнэ. Үүнд:

2.1.1. Хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас гаргах тухай банкны хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, холбогдох нотлох баримт бичиг;

- 2.1.2. Гаргах хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасны тоо, хэмжээ, үнэ, хувьцааг гаргах ажиллагааг хэрэгжүүлэх хугацаа, төлөвлөгөө;
- 2.1.3. Боломжит хөрөнгө оруулагчдын талаарх тандан судалгаа;
- 2.1.4. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө.
- 2.2. Дангаар эсхүл холбогдох этгээдийн хамт банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох тохиолдолд энэ журмын 1.2.2-т заасны дагуу Монголбанкнаас зөвшөөрөл авахдаа банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох этгээд нь Банкны тухай хуулийн 36.19-д заасан шалгуурыг хангасан эсэхийг нотлох баримт бичиг, дараах тодорхойлолт, баримт бичгийг банк Монголбанкинд ирүүлнэ. Үүнд:
- 2.2.1. Энэ журмын Хавсралт 2-ын дагуу гаргасан банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох этгээдийн тодорхойлолт;
- 2.2.2. Энэ журмын Хавсралт 3-ын дагуу гаргасан банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох этгээдийн мэдүүлэг;
- 2.2.3. Шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөртэй эсэх талаар эрх бүхий байгууллагын тодорхойлолт;
- 2.2.4. Эрүүгийн хариуцлага, ял шийтгэл хүлээж байсан эсэх, хүлээж байгаа эсэх тодорхойлолт, лавлагаа;
- 2.2.5. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулах хөрөнгийн хэмжээ, гарал үүслийг нотлох баримт. Үүнд:
- 2.2.5.1. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох этгээд, түүний холбогдох этгээд нь хуулийн этгээд бол үйл ажиллагааны сүүлийн 3 (гурван) жилээс багагүй хугацааны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох этгээд хувь хүн бол сүүлийн 3 (гурван) жилээс багагүй хугацааны цалин, орлогын тодорхойлолт, татварын газрын тодорхойлолт, харилцагч банкны дансны хуулга;
- 2.2.5.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох этгээд, түүний холбогдох этгээд нь хуулийн этгээд бол харьяалах татварын байгууллагаас баталгаажуулсан сүүлийн 3 (гурван) жилээс багагүй хугацааны “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан”, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох этгээд хувь хүн бол сүүлийн 3 (гурван) жилээс багагүй хугацааны “Хувь хүний орлогын албан татварын тайлан”, татварын газрын тодорхойлолт;
- 2.2.6. Шаардлагатай тохиолдолд хөрөнгийн гарал, эх үүсвэрийн баталгаажуулалтын талаар хийсэн хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлт;
- 2.2.7. Шаардлагатай тохиолдолд хувь нийлүүлсэн хөрөнгийн холбогдох баримт бичиг болон хөрөнгө оруулах үйл ажиллагаа нь хууль тогтоомжид заасан шаардлага, шалгуурыг хангасан эсэх талаарх Монголбанкнаас хүлээн зөвшөөрсөн хөндлөнгийн хуулийн байгууллагын дүгнэлт.
- 2.2.8. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох этгээдийн өмчлөл, хяналт, зохион байгуулалтын бүтцийг таньж мэдэхэд Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн мэдээ, баримт бичиг;
- 2.2.9. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох этгээдийн эцсийн өмчлөгч хүртэлх хэлхээ холбоог тогтооход Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн мэдээ, баримт бичиг;
- 2.2.10. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох этгээд нь гадаадын харьяалалтай хуулийн этгээд, эсвэл хувь хүн бол нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч этгээд, эсвэл банкны нөлөө

бүхий хувьцаа эзэмшигч болох хувь хүнтэй холбоотой дараах баримт бичгийг нэмж ирүүлнэ. Үүнд:

2.2.10.1. Харьяалах улс, оронд зээл, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй болохыг нотлох баримт бичиг;

2.2.10.2. Харьяалах улс, оронд ял шийтгэлгүй болохыг нотлох баримт бичиг;

2.2.10.3. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа, гэмт хэрэгт оролцож байгаагүй болохыг нотлох баримт бичиг.

2.3. Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч банкны нийт гаргасан хувьцааны 1 (нэг) болон түүнээс дээш хувиар хувьцаа нэмж эзэмшихээр энэ журмын 1.2.3-т заасны дагуу Монголбанкнаас зөвшөөрөл авахдаа энэ журмын 2.2.5-д заасан баримт бичгийг Монголбанкинд ирүүлнэ.

2.4. Хөрөнгө оруулалтын сан банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болоход энэ журмын 1.2.2-т заасны дагуу Монголбанкнаас зөвшөөрөл авахдаа дараах баримт бичгийг Монголбанкинд ирүүлнэ. Үүнд:

2.4.1. Хөрөнгө оруулалтын сангийн танилцуулга;

2.4.2. Хөрөнгө оруулалтын сангийн дүрэм, хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулалтын бодлого;

2.4.3. Хөрөнгө оруулалтын сангийн менежер, кастодианы талаарх танилцуулга, мэдээлэл;

2.4.4. Хамгийн сүүлийн байдлаар гаргасан хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчийн тухайлсан бүртгэл, хөрөнгө оруулалтын сангийн гишүүдийн бүртгэл.

2.5. Андеррайтерын гэрээний дагуу банкны гаргасан хувьцааг худалдан авсан андеррайтер банкны нийт хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмших тохиолдолд дараах баримт бичгийг Монголбанкинд ирүүлнэ. Үүнд:

2.5.1. Андеррайтерын гэрээ;

2.5.2. Хувьцааг худалдан авах эх үүсвэрийг нотлох баримт бичиг;

2.5.3. Хувьцааг буцаан худалдах нөхцөл, хугацааны талаарх мэдээлэл.

2.6. Банк хувьцаа болон хувьцаанд хамаарах үнэт цаасаа эргүүлэн худалдан авахаар энэ журмын 1.2.4-т заасны дагуу Монголбанкнаас зөвшөөрөл авахдаа зөвшөөрөл хүссэн албан бичгийг дараах баримт бичгийн хамт Монголбанкинд ирүүлнэ. Үүнд:

2.6.1. Хувьцаа болон хувьцаанд хамаарах үнэт цаасыг эргүүлэн худалдан авах тухай банкны хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр (буцаан худалдан авах хувьцааны тоо, нэг бүрийн үнэ, төлбөр хийх хугацаа, ашиглах журам, буцаан худалдан авах болсон шалтгаан, халаасны хувьцааг буцааж худалдах хугацаа, журам зэргийг тодорхой тусгасан байна), хурлын тэмдэглэл;

2.6.2. Хувьцааг буцаан худалдан авч халаасны хувьцаанд бүртгэсний дараа Монголбанкнаас тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ болон өөрийн хөрөнгийн доод хэмжээ болон өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хангаж байгааг харуулсан тооцоо, судалгаа, дүгнэлт;

2.6.3. Компанийн тухай хуулийн 49.1-д заасны дагуу хувьцаа эзэмшигчтэй тохиролцсоны үндсэн дээр хувьцааг буцаан худалдаж авах бол хувьцаа эзэмшигчтэй хийсэн хэлцэл;

2.6.4. Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн дагуу хувьцаа эзэмшигчийн шаардлагаар банк хувьцаагаа эргүүлэн худалдан авах тохиолдолд хувьцаа эзэмшигчийн бичгээр гаргасан шаардлага, түүний шалтгаан.

2.7. Энэ журмын 1.3-т заасны дагуу Монголбанкинд мэдэгдэхдээ дараах баримт бичгийг Монголбанкинд ирүүлнэ. Үүнд:

2.7.1. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах тухай банкны эрх бүхий байгууллагын хурлын шийдвэр, хурлын тэмдэглэл;

2.7.2. Банкны дүрэмд өөрчлөлт орох бол дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлт;

2.7.3. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулахад Санхүүгийн зохицуулах хороо, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад хүргүүлэх баримт бичгийн нэг хувь.

2.8. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах харилцаанд гадаадын харьяалалтай хуулийн этгээд, хувь хүн оролцсон бол энэ журамд холбогдох баримт бичгийг тухайн орны хэлээр үйлдэж, монгол болон англи хэл дээрх албан орчуулгын хамт Монголбанкинд ирүүлнэ.

2.9. Монголбанк энэ журамд заасан баримт бичгээс гадна нэмэлт мэдээ, баримт материал шаардах эрхтэй бөгөөд банкны хувьцаа эзэмшигч, тэдгээрийн холбогдох этгээдтэй холбоотой асуудлаар эрх бүхий байгууллагаас тодорхойлолт, лавлагаа гаргуулан авна.

ГУРАВ. БАНКНЫ ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, БҮТЦЭД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХАД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙГ ХЯНАХ, ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ

3.1. Монголбанк нь банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах хүсэлтийг хянаж, шаардлагатай тохиолдолд тайлбар, тодруулга авч, газар дээр нь шалгана.

3.2. Энэ журамд заасан баримт бичгийн бүрдэл дутуу, нэмэлт баримт бичиг шаардлагатай тохиолдолд Монголбанк нэмэлт баримт бичгийг ирүүлэхийг шаардах бөгөөд бүрэн гүйцэд хүлээн авсан өдрийг хүсэлт хүлээн авсан өдөрт тооцно.

3.3. Монголбанк энэ журмын 1.2-т заасан зөвшөөрлийг олгох эсэх шийдвэрээ энэ журмын 3 дугаар бүлэгт заасан хүсэлт, холбогдох баримт бичгийг бүрэн гүйцэд хүлээн авсан өдрөөс хойш 30 (гуч) хоногийн дотор гаргаж, энэ тухай хүсэлт гаргагч банк, Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 3 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

3.4. Монголбанк шаардлагатай гэж үзвэл энэ журмын 3.3-т заасан шийдвэр өгөх хугацааг 30 (гуч) хоногоор сунгаж болно.

ДӨРӨВ. БАНКНЫ ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, БҮТЦЭД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХООС ТАТГАЛЗАХ ҮНДЭСЛЭЛ

4.1. Монголбанк нь дараах үндэслэлээр банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрөл олгохоос татгалзана. Үүнд:

4.1.1. Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох этгээд нь Банкны тухай хуульд заасан шаардлагыг хангаагүй;

4.1.2. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах нь холбогдох хууль тогтоомж зөрчсөн;

4.1.3. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэр, гарал үүслийг нотлох баримт бичиг хангалтгүй, хувьцаа эзэмшигчийн хууль ёсны үйл ажиллагаанаас олсон орлого болох нь нотлогдоогүй;

4.1.4. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийг зээлийн эх үүсвэрээр бүрдүүлсэн гэж Монголбанк үзсэн, үүнийг нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох этгээд зээлийн эх үүсвэр биш гэдгийг нотолж чадаагүй;

4.1.5. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд тухайн өөрчлөлтийг оруулснаар үндэсний эдийн засгийн аюулгүй байдал болон банк, санхүүгийн салбарын тогтолцооны тогтвортой байдалд сөрөг нөлөөтэй гэж Монголбанк үзсэн;

4.1.6. Монголбанкнаас шаардсан мэдээлэл болон тухайн мэдээллийн нотлох баримтыг ирүүлээгүй, нотлох баримтын үндэслэл, тайлбар нь тодорхойгүй, тэдгээрийг тодорхойлох боломжгүй;

4.1.7. Энэ журмын 3.2-т заасан баримт материалыг Монголбанкнаас шаардсанаас хойш 30 (гуч) хоногийн дотор бүрэн гүйцэд ирүүлээгүй.

ТАВ. ТАЙЛАГНАЛ

6.1. Брокерын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд нь банкны хувьцаа эзэмшигч болох этгээдийн тодорхойлолтыг энэ журмын хавсралт 1-д заасны дагуу бүрдүүлэх үүрэгтэй.

6.2. Банк нь банкны хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг 7 хоног тутам, эсвэл банкны нэг хувьцаа эзэмшигчийн хувь, хэмжээнд 1 болон түүнээс дээш хувиар өөрчлөлт орох тухай бүр Монголбанкинд ирүүлнэ.

6.3. Банк банкны хувьцааны шилжилтийн өдөр тутмын тайланг сар бүрийн 10-ны өдрийн дотор Монголбанкинд ирүүлнэ.

6.4. Банк хувьцаа эзэмшигчийн бүртгэл хөтлөх үүргээ үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж байгаа бол энэ журмын 6.2, 6.3-т үүргийг үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага хүлээнэ.

6.5. Банк нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцийн өөрчлөлтийн тайланг өөрчлөлт гарах тухай бүр болон хагас жил тутам энэ журмын Хавсралт 4-ийн дагуу гаргаж, банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Гүйцэтгэх удирдлагын гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулан дараа сарын 10-ны өдрийн дотор Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд тус тус ирүүлнэ.

ДОЛОО. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

7.1. Монголбанкны зөвшөөрөлгүйгээр хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулсан этгээдэд Банкны тухай хуулийн 36.5, 36.7, 36.8 болон холбогдох хууль тогтоомжид заасан арга хэмжээг авна.

7.2. Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь энэ журмын хавсралт 2-ын дагуу гаргасан банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн тодорхойлолтод өөрчлөлт орох тухай бүр банкинд мэдэгдэх, тодорхойлолтоо шинэчлэн хүргүүлэх үүрэгтэй.

7.3. Банк нь энэ журмын хавсралт 2-ын дагуу гаргасан банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн тодорхойлолтод өөрчлөлт орох тухай бүр хувьцаа эзэмшигчийн бүртгэлийг шинэчилж, Монголбанкинд мэдэгдэх үүрэгтэй.

7.4. Андеррайтеры гэрээний дагуу банкны гаргасан хувьцааг худалдан авсан андеррайтеры эзэмшиж буй хувьцаа нь саналын эрхгүй, ногдол ашиг авах эрхгүй байна.

7.5. Андеррайтеры гэрээний дагуу банкны гаргасан хувьцааг худалдан авсан андеррайтер эзэмшиж буй хувьцаагаа буцаан худалдах хугацаанд худалдаагүй бол Банкны тухай хуулийн 36.8-д заасан арга хэмжээг авна.

7.6. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигч нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болоход Монголбанкнаас зөвшөөрөл авах үүргийг хуульд заасан гэрээ байгуулсан хөрөнгө оруулалтын менежментийн компани хүлээнэ.

7.7. Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛБАНК, САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

..... БАНКНЫ ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧИЙН ТОДОРХОЙЛОЛТ

А.БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ НЬ ХУУЛИЙН ЭТГЭЭД БОЛ:			
Оноосон нэр:			
Улсын бүртгэлийн дугаар:			
Регистрийн дугаар:			
Байгуулагдсан огноо:			
Хуулийн этгээдийн улсын харьяалал:			
Үйл ажиллагааны чиглэл:			
Хаяг:			
Цахим хаяг:			
Холбоо барих утас:			
Хувь нийлүүлсэн хөрөнгө:			
Огноо	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ (төгрөгөөр)	Хувьцааны тоо ширхэг	Нэгж хувьцааны үнэ (төгрөгөөр)
...			
Нийт			

Холбогдох этгээдүүд:				
	Овог, нэр/ Оноосон нэр	Регистрийн дугаар/ Бүртгэлийн дугаар	Ямар холбоотой болох	Эрхэлдэг ажил, албан тушаал/ Үйл ажиллагааны чиглэл
1				
2				
...				

Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбарыг хавсаргав.

Тодорхойлолтыг үнэн зөв гаргасан болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

(гарын үсэг)

(нэр)

..... оны сарын-ний өдөр

Б. БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ НЬ ХУВЬ ХҮН БОЛ:				
Ургийн овог:			Сүүлийн зургаан сарын дотор авахуулсан өнгөт цээж зураг	
Овог:				
Нэр:				
Төрсөн огноо:				
Регистрийн дугаар:				
Иргэншил:				
Оршин суугаа хаяг:				
Цахим шуудангийн хаяг:				
Суурин болон гар утасны дугаар:				
Холбогдох этгээдүүд:				
	Овог, нэр/ Оноосон нэр	Регистрийн дугаар/ Бүртгэлийн дугаар	Ямар холбоотой болох	Эрхэлдэг ажил, албан тушаал/ Үйл ажиллагааны чиглэл
1				
2				
...				
Харилцагч банк				
1				
...				

Хувьцаа эзэмшигчийн иргэний үнэмлэх/паспортын нотариатаар баталгаажуулсан хуулбарыг хавсаргав.

Тодорхойлолтыг үнэн зөв гаргасан болно.

(нэр)

(гарын үсэг)

..... оны сарын-ний өдөр

..... **БАНКНЫ НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА**
ЭЗЭМШИГЧ БОЛОХ ЭТГЭЭДИЙН ТОДОРХОЙЛОЛТ

А.НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ БОЛОХ ЭТГЭЭД НЬ ХУУЛИЙН ЭТГЭЭД БОЛ:				
Оноосон нэр:				
Улсын бүртгэлийн дугаар:				
Регистрийн дугаар:				
Байгуулагдсан огноо:				
Хуулийн этгээдийн улсын харьяалал:				
Үйл ажиллагааны чиглэл:				
Хаяг:				
Цахим хаяг:				
Холбоо барих утас:				
Хувь нийлүүлсэн хөрөнгө:				
Огноо	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ (төгрөгөөр)	Хувьцааны тоо ширхэг	Нэгж хувьцааны үнэ (төгрөгөөр)	
...				
Нийт				
Холбогдох этгээдүүд:				
	Овог, нэр/ Оноосон нэр	Регистрийн дугаар/ Бүртгэлийн дугаар	Ямар холбоотой болох	Эрхэлдэг ажил, албан тушаал/ Үйл ажиллагааны чиглэл
1				
2				
...				

Эрх бүхий албан тушаалтан:

1	Албан тушаал:	
	Овог, нэр:	
	Регистрийн дугаар:	
	Яс, үндэс:	
	Иргэншил:	
	Оршин суугаа хаяг:	
	Цахим шуудангийн хаяг:	
	Холбоо барих утас:	
...		

Гүйцэтгэх удирдлагын түүх: (он дарааллаар бичнэ үү)

	Албан тушаал	Овог нэр	Хугацаа
1			
2			
3			
...			

Хараат болон охин компанитай бол доорх хүснэгтийг бөглөнө үү:

	Оноосон нэр, Бүртгэлтэй улсын нэр	Эзэмшлийн хувь	Улсын бүртгэлийн дугаар	Регистрийн дугаар
1				
2				
3				
...				

Өөр хуулийн этгээд, банкинд хувь эзэмшдэг бол доорхыг бөглөнө үү:

	Оноосон нэр, Бүртгэлтэй улсын нэр	Эзэмшлийн хувь
1		
2		
...		

Хэрэв хувьцаа эзэмшигч хуулийн этгээд нь аливаа нэг хуулийн этгээдийн охин эсвэл хараат компани бол толгой компанийн тухай мэдээллийг доорх хүснэгтэд бөглөнө үү:

Оноосон нэр, Бүртгэлтэй улсын нэр	
Улсын бүртгэлийн дугаар, Регистрийн дугаар	
Үйл ажиллагааны чиглэл	

Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн нийт хувьцааны 5%-аас илүү хувийг шууд болон шууд бус хэлбэрээр эзэмшдэг хувь хүн, тэдгээрийн холбогдох этгээдийн тухай мэдээллийг доорх хүснэгтэд бөглөнө үү.

	Овог, нэр	Регистрийн дугаар	Эзэмшлийн хувь
1			
2			
...			

Хувьцаа эзэмшигчдийн бүтцийг диаграмм хэлбэрээр доорх хүснэгтэд оруулна уу

(Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн охин болон хараат компани, хувьцаа эзэмшдэг компани, үүсгэн байгуулагчийн толгой компани болон хувьцаа эзэмшигчид, тэдгээрийн эзэмшлийн хувийг харуулсан нарийвчилсан диаграммыг энд зурна уу)

Харилцагч банк

1	
2	
...	

Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбарыг хавсаргав.

Тодорхойлолтыг үнэн зөв гаргасан болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

(гарын үсэг)

(нэр)

..... оны сарын-ний өдөр

Б. НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ БОЛОХ ЭТГЭЭД НЬ ХУВЬ ХҮН БОЛ:

Ургийн овог:		сүүлийн зургаан сарын дотор авахуулсан өнгөт цээж зураг	
Овог:			
Нэр:			
Төрсөн огноо:			
Регистрийн дугаар:			
Иргэншил:			
Оршин суугаа хаяг:			
Цахим шуудангийн хаяг:			
Суурин болон гар утасны дугаар:			
Ажил эрхлэлт:			
Одоо эрхэлж байгаа ажил, албан тушаал:			
Ажлын хаяг, утасны дугаар:			
Урьд өмнө эрхэлж байсан ажил, албан тушаал: (он дарааллаар бичнэ үү)			
Хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан бол доорх хүснэгтийг бөглөнө үү.			
	Байгууллагын нэр,	Улсын бүртгэлийн дугаар	Регистрийн дугаар

	Бүртгэлтэй улсын нэр		
1			
2			
...			

Хуулийн этгээд, банкны хувьцааг шууд болон шууд бус хэлбэрээр эзэмшдэг бол доорхыг бөглөнө үү.

	Оноосон нэр, Бүртгэлтэй улсын нэр	Эзэмшлийн хувь	Улсын бүртгэлийн дугаар, Регистрийн дугаар
1			
2			
...			

Холбогдох этгээдүүд:

	Овог, нэр/ Оноосон нэр	Регистрийн дугаар/ Бүртгэлийн дугаар	Ямар холбоотой болох	Эрхэлдэг ажил, албан тушаал/ Үйл ажиллагааны чиглэл
1				
2				
...				

Харилцагч банк

1	
...	

Хувьцаа эзэмшигчийн иргэний үнэмлэх/паспортын нотариатаар баталгаажуулсан хуулбарыг хавсаргав.

Тодорхойлолтыг үнэн зөв гаргасан болно.

(нэр)

(гарын үсэг)

..... оны сарын-ний өдөр

**..... БАНКНЫ НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ БОЛОХ ЭТГЭЭД
ЭТГЭЭДИЙН МЭДҮҮЛЭГ**

1	Та өөр улсын эрх бүхий байгууллагад банк, санхүүгийн байгууллага болон бусад байгууллагын эрх бүхий албан тушаалтнаар томилогдох зөвшөөрөл авах хүсэлт гаргаж байсан уу? Таны хүсэлтийг хүлээж аваагүй, эсвэл татгалзсан тохиолдол бий юу?
2	Та аль нэг улсад иргэний, эрүүгийн шүүхийн шийдвэрээр ял, шийтгэл эдэлж байсан уу (18 нас хүрэхээс өмнө үйлдэж байсан гэмт хэрэг, тээврийн хэрэгсэл эзэмшихтэй холбоотой зөрчлийг хялбарчилсан журмаар шийдвэрлэсэн бол энд хамаарахгүй)? Хэрэв тийм бол дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү.
3	Санхүүгийн байгууллагатай холбоотой мөрдөн шалгах ажиллагаанд холбогдож байсан уу? Хэрэв тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг бичнэ үү.
4	Та өөрийн өмнө ажиллаж байсан байгууллага, аж ахуйн нэгжийн хянан зохицуулагч байгууллага, мэргэжлийн байгууллагын шийдвэрээр сахилгын хариуцлага хүлээж байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг бичнэ үү.
5	Та өмнө нь луйвар, залилан, эсвэл ижил төрлийн гэмт хэрэгтэй холбоотой байж болзошгүй орлогын талаар мэдүүлэг өгч байсан уу (хараат бус шинжээчээр ажиллаж байсан бол хамаарахгүй)? Хэрэв тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг бичнэ үү.
6	Таны хувьцаа эзэмшдэг /гүйцэтгэх удирдлага, ажилтнаар нь ажилладаг/ үйл ажиллагааг нь удирдан чиглүүлдэг байсан болон/эсхүл одоо байгаа байгууллага, нөхөрлөл нь төрийн, мэргэжлийн, эсвэл бусад төрлийн зохицуулагч байгууллагын зүгээс мөрдөн шалгах ажиллагаанд холбогдож байсан уу? Хэрэв тийм бол энэ талаар мэдээлэл өгнө үү.
7	Таныг албан тушаалаас тань огцруулж байсан, эсвэл албан тушаалд томилогдохтой холбогдуулан татгалзаж байсан уу? Хэрэв тийм бол энэ талаар мэдээлэл өгнө үү.
8	Таныг өөр улсад шүүхийн шийдвэрээр дампуурсанд тооцож байсан уу? Хэрэв тийм бол холбогдох мэдээллийг өгнө үү.
9	Та өөр улсад шүүхийн шийдвэрээр төлбөр барагдуулах шийдвэрийг гүйцэтгэх боломжгүй болж байсан уу? Хэрэв тийм бол холбогдох мэдээллийг өгнө үү.
10	Та хуулийн этгээд үүсгэн байгуулах, үйл ажиллагааг нь удирдан чиглүүлэхтэй холбоотой, эсвэл хуулийн этгээдийн удирдлага, ажилтны эсрэг залилан, эрх мэдлээ урвуулан ашиглах, бусад албан тушаалын гэмт хэрэгт холбогдон аль нэг улсад иргэний болон эрүүгийн хэрэг үүсгэгдэн шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж байсан уу? Хэрэв тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг өгнө үү.
11	Таны удирдан чиглүүлж байсан, гүйцэтгэх удирдлагаар нь ажиллаж байсан, хувьцаа эзэмшиж байсан, эсвэл ажилтан нь байсан байгууллага, нөхөрлөл нь өр төлбөрөө бүхэлд нь, эсвэл хэсэгчлэн барагдуулж чадаагүй тохиолдол бий юу? Таныг албан тушаалаасаа чөлөөлөгдсөний дараа нэг жилийн дотор ийм тохиолдол гарсан уу? Тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг өгнө үү.

12	Таны удирдан чиглүүлж байсан, гүйцэтгэх удирдлагаар нь ажиллаж байсан, хувьцаа эзэмшиж байсан, ажилтан нь байсан байгууллага, нөхөрлөл үйл ажиллагааны тусгай зөвшөөрлөө цуцлуулж байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг өгнө үү.
13	Та өмнө нь итгэлцэл болон түүнтэй адилтгах харилцаанд зөрчил гаргаж байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг өгнө үү.
14	Та энэ байгууллагад хэн нэгэн гуравдагч этгээдийн удирдлага, зааварчилгааны дор ажиллах/ажиллаж байна уу? Хэрэв тийм бол дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү.
15	Та холбогдох хууль эрх зүй, зохицуулалтын болон мэргэжлийн стандарт шаардлагыг дагаж мөрдөхөд бэлэн үү?

Би энэ тодорхойлолтыг гаргаснаар мэдүүлсэн бүх мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэд гэдгийг баталж байна. Мөн дээр дурдсан банкны байгууллагын хувьцаа эзэмшигч байх хугацаанд энэ асуулгад мэдүүлсэн мэдээлэлд өөрчлөлт орох тохиолдолд эрх бүхий байгууллагад 21 хоногийн дотор мэдэгдэх болно.

Би дээрх мэдүүлгийн эсрэг баримт нотолгоо гарч ирсэн, эсхүл санаатай худал мэдүүлсэн тохиолдолд Банкны тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хуулийн дагуу хариуцлага хүлээх болно.

Овог, нэр _____ Гарын үсэг _____ Огноо _____

ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, БҮТЦЭД ОРСОН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

..... оны сарын-ний өдрийн байдлаар

1.Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн өөрчлөлт

	Хувьцаа эзэмшигчийн овог, нэр	Хувь нийлүүлсэн хөрөнгийн эхний үлдэгдэл (он/сар/өдөр)	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд гарсан өөрчлөлт (+,-)	Хувь нийлүүлсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл (он/сар/өдөр)
1				
2				
...				

2.Хувь нийлүүлсэн хөрөнгөд нэмж оруулсан хөрөнгийн гүйлгээний тэмдэглэл

	Огноо	Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурлын шийдвэрийн дугаар, огноо	Хувь нийлүүлсэн хөрөнгийн эхний үлдэгдэл	Хувь нийлүүлсэн хөрөнгөд нэмж оруулсан хөрөнгө (төгрөгөөр)	Хувь нийлүүлсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	Гүйлгээ хийсэн нягтлан бодогч (гарын үсэг, тэмдэг)
1						
2						
...						

3.Өрийг хувьцаанд шилжүүлсэн гүйлгээний тэмдэглэл

	Огноо	Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурлын шийдвэрийн дугаар, огноо	Хувь нийлүүлсэн хөрөнгийн эхний үлдэгдэл	Хувьцаанд шилжүүлсэн өрийн мөнгөн дүн (төгрөгөөр)	Хувь нийлүүлсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	Гүйлгээ хийсэн нягтлан бодогч (гарын үсэг, тэмдэг)
1						
2						
...						

4.Ногдол ашиг хуваарилсан гүйлгээний тэмдэглэл

	Огноо	Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурлын шийдвэрийн дугаар, огноо	Хувь нийлүүлсэн хөрөнгийн эхний үлдэгдэл	Хуваарилсан ногдол ашгийн мөнгөн дүн (төгрөгөөр)	Хувь нийлүүлсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	Гүйлгээ хийсэн нягтлан бодогч (гарын үсэг, тэмдэг)
1						
2						
...						

5.Хувьцааг буцаан худалдан авсан гүйлгээний тэмдэглэл

	Огноо	Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурлын шийдвэрийн дугаар, огноо	Буцаан худалдан авсан хувьцааны мөнгөн дүн	Хувь нийлүүлсэн хөрөнгийн эхний үлдэгдэл	Хувь нийлүүлсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	Гүйлгээ хийсэн нягтлан бодогч (гарын үсэг, тэмдэг)
1						
2						
...						

6.Хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлийг шилжүүлсэн (худалдсан, шүүхийн болон эрх хүлээн авагчийн шийдвэрээр хасалт хийсэн болон нэмсэн, гэрээслэлээр өвлөх, бэлэглэлийн гэрээ болон бусад хууль ёсны замаар хувьцаа шилжүүлсэн) тухай тэмдэглэл

	Огноо	Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурлын шийдвэрийн дугаар, огноо	Өмчлөлийг шилжүүлсэн хувьцааны мөнгөн дүн	Өмчлөлийг шилжүүлэн өгсөн хувьцаа эзэмшигчийн овог, нэр	Өмчлөлийг шилжүүлэн авсан этгээдийн овог, нэр	Гүйлгээ хийсэн нягтлан бодогч (гарын үсэг, тэмдэг)
1						
2						
...						